

I маягт

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2025 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар тогтоолын ... дүгээр хавсралт

Дүүргийн Эрүү Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхэд  
/Огноо/ /Газар/

## НЭХЭМЖЛЭЛ

/Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа- I маягт/

### I. ЗОХИГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

#### Нэхэмжлэгч:

Иргэний овог нэр/Хуулийн этгээдийн нэр, зохион байгуулалтын хэлбэр: Хас Банк ХК  
Оршин суух/байх хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Ерөнхий Сайд Амарын гудамж, ХасБанкны төв байр, ШХ 20А, 72

Иргэний бүртгэлийн дугаар:.....

Хуулийн этгээд бол регистрийн дугаар: 257869х

Цахим шуудангийн хаяг: narantsetsegt@хасбанк.mn

Утасны дугаар: 7577188х, 9689060х

*/хэд хэдэн нэхэмжлэгчтэй бол нэхэмжлэгч тус бүрээр дээрх мэдээллийг өгч хавсаргана уу/*

#### Хариуцагч:

Иргэний овог нэр/Хуулийн этгээдийн нэр, зохион байгуулалтын хэлбэр: Төрбат овогтой Түвшинбаяр

Оршин суух/байх хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 38 дугаар хороо, Улаанхуаран 10 дугаар гудамж, 214х тоот

Иргэний бүртгэлийн дугаар: РД0527192х

Хуулийн этгээд бол регистрийн дугаар:

Цахим шуудангийн хаяг: turbat\_tuvshinbayar@gmail.com

Утасны дугаар: 8875456х, 9975456х

*/хэд хэдэн хариуцагчтай бол хариуцагч тус бүрээр дээрх мэдээллийг өгч хавсаргана уу/*

### II. НЭХЭМЖЛЭЛИЙН ШААРДЛАГА:

Мөнгөн хөрөнгө гаргуулах /3.1, 3.2, IV, V, VI хэсгүүдэд хариулна уу/

*(Таны шаардаж байгаа мөнгөн хөрөнгө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй хэмжээтэй байх ёстой.)*

Барьцааны зүйлээс үүргийг хангуулах /3.2, V, VI хэсгүүдэд хариулна уу/

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүчингүй болгуулах /3.3, V, VI хэсгүүдэд хариулна уу/

**III. МАРГААНЫ АГУУЛГА:****3.1. Хариуцагчаас мөнгөн хөрөнгө гаргуулах болсон үндэслэлийг сонгоно уу.**

- Хариуцагчтай байгуулсан гэрээ, хэлцлийн дагуу шаардаж байгаа мөнгөн хөрөнгө *(А-1-А-15 маягтаас тохирохыг бөглөнө үү)*
- Дундын өмчийн ашиглалт, засвар үйлчилгээний үнэ *(Б-1 маягтыг бөглөнө үү)*
- Хөдөлмөрийн гэрээний дагуу олгоогүй цалин хөлс *(Б-2 маягтыг бөглөнө үү)*
- Эд хөрөнгө, эрүүл мэндэд учирсан гэм хор *(Б-3 маягтыг бөглөнө үү)*
- Ажилд эгүүлэн тогтоосон хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг үндэслэн ажилгүй байсан хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх олговор *(Б-4 маягтыг бөглөнө үү)*

**3.2. Барьцааны зүйлээс үүргийг хангуулах шаардлагын талаар тодруулна уу.**

- Мөнгө төлүүлэх ба барьцааны шаардлагыг хамт гаргаж байна. *(А-13 маягтыг бөглөнө үү)*
- Мөнгө төлөх шүүхийн шийдвэрийг өмнө нь гаргуулсан тул барьцааны шаардлагыг дангаар нь гаргаж байна. *(А-13 маягтыг бөглөнө үү)*
- Хариуцагч мөнгө төлөхийг зөвшөөрсөн боловч барьцааг зөвшөөрөхгүй байх тул барьцааны шаардлагыг дангаар нь гаргаж байна. *(А-13 маягтыг бөглөнө үү)*

**3.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой дараах шаардлагыг гаргаж байна.**

- Хөрөнгийг битүүмжлэх, хураах ажиллагааны талаарх шаардлага *(Б-5 маягтыг бөглөнө үү)*
- Хөрөнгийн үнэлгээ тогтоох ажиллагааны талаарх шаардлага *(Б-6 маягтыг бөглөнө үү)*
- Хөрөнгийг дуудлага худалдаанд оруулах ажиллагааны талаарх шаардлага *(Б-7 маягтыг бөглөнө үү)*

**IV. ГЭРЭЭНИЙ МАРГААН: Мөнгөн хөрөнгө гаргуулах болон барьцааны үүргийг шаардах үндэслэл болсон гэрээ нь**

- Худалдах-худалдан авах гэрээ *(А-1 маягтыг бөглөнө үү)*
- Зээлийн гэрээ *(А-2 маягтыг бөглөнө үү)*
- Банк ба банк бус санхүүгийн байгууллагын зээлийн гэрээ *(А-3 маягтыг бөглөнө үү)*
- Бэлэглэлийн гэрээ *(А-4 маягтыг бөглөнө үү)*
- Эд хөрөнгө хөлслөх гэрээ *(А-5 маягтыг бөглөнө үү)*
- Түрээсийн гэрээ *(А-6 маягтыг бөглөнө үү)*

- Санхүүгийн түрээсийн гэрээ *(А-7 маягтыг бөглөнө үү)*
- Ажил гүйцэтгэх гэрээ *(А-8 маягтыг бөглөнө үү)*
- Даатгалын гэрээ *(А-9 маягтыг бөглөнө үү)*
- Мөнгөн хадгаламжийн гэрээ *(А-10 маягтыг бөглөнө үү)*
- Зуучлалын гэрээ *(А-11 маягтыг бөглөнө үү)*
- Тээвэрлэлтийн гэрээ *(А-12 маягтыг бөглөнө үү)*
- Барьцааны гэрээ *(А-13 маягтыг бөглөнө үү)*
- Хамтран ажиллах гэрээ *(А-14 маягтыг бөглөнө үү)*
- Бусад гэрээ *(А-15 маягтыг бөглөнө үү)*

**V. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой тодруулах асуулт:**

5.1. Та хариуцагчийн оршин суугаа хаягийн дагуу шүүхэд нэхэмжлэл гаргаж байна уу?

- Тийм
- Үгүй

5.2. Нэхэмжлэлд дурдсан үйл баримт, зохигчийн гэм буруугийн талаар хуулийн хүчин төгөлдөр шүүхийн болон арбитрын шийдвэр байгаа юу?

- Тийм
- Үгүй

5.3. Маргаж байгаа зүйл болон түүний үндэслэлийн талаарх өөр хэргийг шүүх шийдвэрлэж байгаа, эсхүл эрүүгийн журмаар шалгаж байгаа юу?

- Тийм
- Үгүй

5.4. Та хариуцагчтай эвлэрэн хэлэлцэх хүсэлтэй юу?

- Тийм
- Үгүй

5.5. Маргааныг эвлэрүүлэн зуучлал, эсхүл арбитраар шийдвэрлүүлэхээр тохиролцсон уу?

- Тийм
- Үгүй

5.6. Шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журмаар хуульд заасан байгууллагад хандсан уу?

- Тийм
- Үгүй

**VI. Нэхэмжлэлд хавсаргасан баримтын жагсаалтыг хавсаргана уу.**

1. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт - 2 хуудас;
2. ХасБанкны Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар - 1 хуудас;

3. ХасБанкны Гүйцэтгэх захирлын 2024 оны 02 дугаар сарын А/310 дугаар тушаалын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар - 1 хуудас;
4. Шүүхэд төлөөлөх итгэмжлэл - 1 хуудас;
5. 201010824х дугаартай Зээлийн гэрээ, түүний хавсралтыг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар - 2 хуудас;
6. 500581487х дугаартай дансны хуулга - 1 хуудас;
7. 201010824х дугаартай дансны хуулга - 1 хуудас;
8. Зээлдэгчийн иргэний үнэмлэхний цахим лавлагаа нотариатаар гэрчлүүлсэн хуулбар - 1 хуудас;

ГАРЫН ҮСЭГ:

**Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны  
тойргийн шүүхэд**

/Огноо/

/Газар/

**БАНК, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДЭЭС ОЛГОСОН  
ЗЭЭЛИЙН ГЭРЭЭНИЙ ДАГУУ МӨНГӨН ХӨРӨНГӨ ГАРГУУЛАХ ШААРДЛАГА**

/Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа- А-3 маягт/

**1. Нэхэмжлэлийн шаардлагын дүн: 7,585,000 төгрөг**

*(Таны шаардаж байгаа мөнгөн хөрөнгө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй хэмжээтэй байх ёстой.)*

- 1.1. Энэхүү мөнгөн дүнд:  
Үндсэн зээл: 6580,000 төгрөг  
Зээлийн хүү: 923,300 төгрөг  
Нэмэгдүүлсэн хүү: 81700 төгрөг  
Бусад: 0 төгрөг

*(Хэрэв та тухайн шаардлагыг гаргаагүй бол харгалзах хэсэгт 0 дүн тавина уу)*

**2. Нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл:**

- Зээлийн гэрээний үүргийг гүйцэтгүүлэх
- Зээлийн гэрээг хугацаанаас өмнө цуцалж, мөнгөн хөрөнгө гаргуулах
- Учирсан хохирлыг гаргуулах
- Бусад

**3. Зээлийн төлбөр гаргуулах шаардлагаа үндэслэж байгаа гэрээ нь дараах аль төрлийн гэрээнд хамаарах вэ?**

- Банктай байгуулсан зээлийн гэрээ
- Банк бус санхүүгийн байгууллагатай байгуулсан зээлийн гэрээ
- Цахим зээлийн гэрээ буюу цахим аппликейшн ашигласан гэрээ
- Бүртгэлтэй иргэнтэй байгуулсан зээлийн гэрээ

**4. Тийм, Үгүй гэсэн хариултын аль нэгийг сонгоно уу?**

- 4.1. Зээлдүүлэгч нь зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй юу?
- Тийм
  - Үгүй
- 4.2. Зээлийн гэрээг бичгээр байгуулсан уу?
- Тийм
  - Үгүй
- 4.3. Цахим зээлийн гэрээ байгуулсан уу?
- Тийм
  - Үгүй
- 4.4. Зээлийн гэрээнд хүү төлөхөөр тохиролцсон уу?
- Тийм
  - Үгүй
- 4.5. Зээлийн гэрээнд нэмэгдүүлсэн хүү тохиролцсон уу?

- Тийм  
 Үгүй
- 4.6. Зээлийн гэрээний хугацаа дууссан уу?  
 Тийм  
 Үгүй /4.7-д хариулах шаардлагагүй/
- 4.7. Зээлийн гэрээний хугацааг сунгасан уу?  
 Тийм  
 Үгүй
- 4.8. Зээлийн гэрээний үүргээ биелүүлэхийг нөгөө талаасаа шаардсан уу?  
 Тийм  
 Үгүй

**5. Гэрээ байгуулсан огноо:** 2024 оны 06 сарын 24 өдөр

**6. Гэрээ дуусгавар болох огноо:** 2026 оны 12 сарын 12 өдөр

**7. Зээл буцаан төлсөн огноо:**.....

**8. Хийсэн буцаан төлөлт бүрийн дүн:**

8.1 үндсэн зээлийн төлбөр ..... төгрөг,

8.2 үндсэн хүүгийн төлбөр .....төгрөг,

8.3 нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр ..... төгрөг

**9. Буцаан төлсөн нийт мөнгөн хөрөнгийн дүн:**.....

**10. Зээлийн гэрээний үүрэг зөрчигдөж эхэлсэн огноо:** 2025 оны 01 сарын 12

**11. Нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл, үйл баримт, зээл олголт, төлөлтийн тооцооллын талаар ач холбогдолтой гэж үзсэн нөхцөл байдлын талаар 300 үгэнд багтаан бичнэ үү. (Зээл олголт, төлөлтийн тооцоолол, огноог хүснэгтээр харуулан хавсаргана уу.)**

**12. Хавсаргасан баримтыг жагсаана уу.** Зээл, хүүний тооцоолол - 1 хуудас;

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, "Банк, эрх бүхий хуулийн этгээд энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу бичгээр гэрээ байгуулан данс нээсэн харилцагчид тухайн данстай холбоотой хадгаламж, шилжүүлэг, зээлийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлж болно", 7.2-т "Энэ хуулийн 7.1-д заасны дагуу цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхэд нууцлалын шаардлага А-3 маягт хангасан нууц уг, нууц код, цахим гарын үсэг зэргийг ашиглаж болох бөгөөд эдгээрийг цахим хэлбэрээр хийсэн шилжүүлэг, зээлийн гэрээ, бусад хэлцэлд зурсан гарын үсэгтэй адилтгаж үзнэ." гэж тус тус заасны дагуу иргэн Т.Түвшинбаяр нь 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдөр цахимаар 7,585,000 төгрөгний дүнтэй, 365 хоногт 20.4 хувийн хүүтэй, 30 сарын хугацаатай, 201010824х дугаартай зээлийн гэрээ байгуулсан. Банк нь 2024 оны 06 сарын 24-ний өдөр Т.Түвшинбаярын ХасБанкны 5005814879 дугаартай харилцах дансанд 7,585,000 төгрөгийг шилжүүлж, гэрээний үүргээ биелүүлсэн. Зээлдэгч нь Банктай байгуулсан 201010824х дугаартай Зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчиж, нэхэмжлэл гаргах өдрийн байдлаар 130 хоног хугацаа хэтрүүлээд байна. Иймд Иргэний хуулийн 453 дугаар зүйлийн 453.1, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон 201010824х дугаартай Зээлийн гэрээг цуцалж, гэрээний дагуу төлөгдөөгүй үндсэн зээлийн төлбөр болох 6580,000 төгрөг, 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн

А-3 маягт

байдлаарх хүү 923,300 төгрөг, нэмэгдүүлсэн хүү 81700 төгрөг төгрөг, нийт 7,585,000 төгрөгийг хариуцагч Т.Түвшинбаяраас гаргуулж өгнө үү.

НЭХЭМЖЛЭЛ ГАРГАСАН: